

## НИШИДА КИТАРОГИЙН ФИЛОСОФИ ДАХЬ ҮНДЭСНИЙ ҮЗЭЛ БА ОРЧИН ҮЕ

Д. Оюунгэрэл- ХААИС-ийн багш, доктор

**Түлхүүр үг. Бүшидо, үндэсний үзэл, зовинол**

**Товч утга.** Мейжийн шинэчлэлийн дараах японы нийгэм нь “баруунжих үзэл”, “орчин үежүүлэх үзэл” гэсэн үзэл бодлын тэмцлийн түүх байсан. Эхэн үедээ хүмүүс нийгэмд гарсан өөрчлөлт, гадны нөлөөг эсэргүүцэн дургүйцлээ илэрхийлж байв. Гэсэн хэдий ч ард олонд шинэ, орчин үежсэн улс байгуулах, мөн хуучин системээс ангижрах талаар шинэ засгийн газрын улс төрийн лидерүүд идэвхтэй сурталчилгаа хийж байлаа. “Өрнө болон дорно” гэсэн нэр томъёо нь бараг бүх талын харилцаа, амьдралын хэв маягт гүн шингэсэн байлаа. Улс төрийн элитүүд Япон хэмээгдэх орчин үеийн үндэстний улсыг хэрхэн бий болгох вэ гэдэг талаар ихэд маргалддаг байсан байна. Тэр үед боловсролыг шинэчлэгчид шинжлэх ухаан болон уламжлал, ёс заншлын хоорондох тэнцвэрийг хянах шаардлагатай гэж үзэж байлаа. Ийнхүү тэд хөгжлийн асуудлыг тал бүрээс нь нухацтай авч хэлэлцсээр XX зуунтай золгожээ.

1930, 1940-өөд оны үед ч японы нийгмийн болон философийн салбарт ихээхэн өөрчлөлт хөдөлгөөнтэй он жилүүд байсан юм. Өрнийн соёлын нөлөө япон оронд урьд өмнөхөөсөө илүү орж ирснээр хүмүүсийн сэтгэхүй, нийгмийн амьдралд хүчтэй цохилт болсон юм. Түүхийн энэ үеэс азийн боловсрол болон соёлын амьдралд “баруунжсан”, “орчин үежсэн” гэсэн утгатай үг өргөнөөр хэрэглэгдэх болсон бөгөөд японы зарим сэхээтнүүд өрнийн соёлын эсрэг зогсож байлаа. Энэ үед дэлгэрч байсан өрнийн онолын үзэл баримтлал нь дайны үед сэргэж, тухайн үед хүчээ авч байсан үндсэрхэг үзэлтэй өрсөлдөн гарч ирсэн юм. Тиймээс өрнийн философийг сурталчилсан Нишида Китарогийн зарим үзэл санааг японы онцлог, үндэсний үзэлд төдийлэн нийцэхгүй гэж үзэж байв. Учир нь Нишида Китаро өрнийн философийн үзэл баримтлалыг идэвхийлэн судалж, сурталчилж байжээ.

Гэхдээ тэрээр зөвхөн өрнийн философийг “шүтэгч” биш байсан. Үүний тод жишээ бол “Их үйлсээс харагдахуйд”, “Ухамсар дахь ахуйн биш тодорхойлолт” зэрэг зохиолдоо нэгэн цаг үе дор ажиллаж амьдарч байсан соён гэгээрүүлэгч Фүкүзава Юкичигийн<sup>23</sup> дэвшүүлсэн “Улс орноо сүртэй болгох нэг арга бол өрнөдийн ном зохиолыг аль болох их уншиж судлах явдал” хэмээснийг сайшааж, бид өөрсдийн соёлыг дээшлүүлэхийн тулд өрсөлдөгч соёлоо мэддэг байх, улмаар үндэсний соёлын давуу талыг чухалчлах хэрэгтэй санааг илэрхийлсэн байдаг.

Эхэн үедээ Нишида Китаро, Фүкүзава Юкичи зэрэг сэтгэгчид барууны либерал, демократ үзэл суртлыг бүхэл бүтнээр нь хүлээн авч, шинэчлэл өрнөжих үйл явцыг дэмжиж байсан нь үндэсний ёс заншлын хүчтэй эсэргүүцэлтэй эхэн үедээ тулгарсан юм. Тэд “өөрсдийн соёлыг дээшлүүлэхийн тулд өрсөлдөгч соёлоо мэддэг байх” тухай үзлээ эрхлэн гаргадаг сониноороо дамжуулан илэрхийлсээр байсан хэдий ч консерватив үзэлтнүүд хуучин амьдралын хэв маяг, зан заншлыг хэвээр нь авч үлдэн үргэлжүүлэхийг

<sup>23</sup> Фүкүзава Юкичи /1834-1901/ Мэйжигийн үеийн их соён гэгээрүүлэгч, сэтгэгч. Кэй-Оогийн их сургуулийг үндэслэгч. Өрнөдийн соёлыг нэвтэрхий мэдэж ойлгосон хүн байжээ.

идэвхтэйгээр сурталчилж байсан. Жишээ нь, мейжийн шинэчлэлийн үеийн гол улс төрч, нийгмийн зүтгэлмэн Такомори Сайго гадаад ертөнцийг эсэргүүцэж, "самүрайн сэтгэл"-ийг магтан, түүнийг бишрэн шүтэх үзлийг номлож байснаараа алдартай юм. Тэрээр нийгмийн шинэчлэлийг хүлээн зөвшөөрч байсан хэдий ч энэ үйл явдал нь өрнийн соёлын нөлөөллөөр хийгдэхийн эсрэг тэмцэж, улмаар үндэсний хөдөлгөөнийг байгуулж түүнийгээ тэргүүлж байсан билээ.

Нийгмийн өөрчлөлт шинэчлэлийн энэ цаг үед японы орчин үеийн философийн үзэл санаа шинэ агуулгаар бүрэлдэн бий болсон гэж хэлж болно. Эхэн үедээ японы сэтгэгчид өрнийн философичдийн тайлбар дээр л төвлөрч байсан. Гэсэн хэдий ч "өрнийн рационалист" үзэл болон "японы уламжлалт үзэл баримтлалын үнэ цэнэ" хоёрын хооронд хурцадмал байдал үүссэн байна. Нишида Китаро "Европын философийн сэтгэлгээнд "өрнө дахин" бол "ертөнцийг төлөөлж", философи нь хүний оюун ухаан гэж яригддаг үнэнийг олох явдал гэсэн туйлширсан байдлыг шүүмжилж, өрнө хийгээд дорнын соёлыг тэнцүү хэмжээнд үнэлэх ёстой" хэмээн үзэж байжээ.

Тэрээр дорнын соёлын нөлөөг дээшлүүлэхийн чухлыг өөрийн үндэсний үзлээрээ дамжуулж тайлбарлахыг хичээсэн. Ингэх гол шалтгааныг дорнын соёл бол хүний дотоод ертөнц рүү хандсан хүмүүнлэг соёл тул энэ соёлын нөлөөг дээшлүүлэх нь ирээдүйд нэн чухал болохыг тэрээр онцолжээ.

Японы үндэсний үзэл нь орчин үеийн самүрайн урлаг бүшидод нэвт шингэсэн байна. Үүний мөн чанар нь амин хувиа хичээхгүй байх, өөрийгөө золиослох гэх мэт өнөөгийн ойлголтоор бол үндэстэндээ үйлчлэхийг сургасан агуулгатай. Жишээ нь тэд арилжаа наймаа хийхийг ашиг олох, түншүүдийн хоорондын харилцаа нэмэгдэх гэхээсээ илүү үндэсний хүчийг нэмэгдүүлэх, ноёрхлоо бататгах, өрсөлдөгчөө ялах, хариуцлагыг дээшлүүлэх гэсэн өргөн утгаар авч үздэг. Тиймдээ ч өнөөдөр япончууд илүү хүчирхэг улс болсон байна.

Үндэсний үзлийн дархлаа сулрах, сул дорой байдлын нэг хэлбэр бол ард түмэндээ сэтгэл ханамжгүй байх явдал хэмээн тэрээр үзсэн нь өнөөгийн бидний амьдралын бие биеэ үгүйсгэсэн, үл ойшоосон байдлыг хэлсэн мэт. "Гадныхан манай улсад өөрийн хүссэнээр бизнес хийх, худалдаа хийх эрхтэй байхад бид залхуу хойрго байвал бидний үүрэг хариуцлага эсрэгээрээ эргэх болно"<sup>24</sup> хэмээн японы соён гэгээрүүлэгч Фүкүзава Юкичи сануулсан байдаг. Түүний хэлсэн үгний утга гүн агаад өнөөдөр бидэнд ч анхаарах зүйл юм. Бид залхуу хойрго, хойч үеэ бус зөвхөн өөрийгөө, амин хувиа хичээх нь их байх юм бол манай улсад бизнес эрхэлж буй гадныхан баян тансаг амьдарч, эх нутаг руугаа баялгийг мөнгө болгон авч явна. Бидэнд харамсах сэтгэл, амаа барих зүйлээс өөр зүйл үлдэхгүй. Энэ байдлыг засах арга бол тэдний боловсруулсан "Дотроо эвтэй, гаднаа өрсөлдөөнч" хэмээх зарчим байж болох юм.

<sup>24</sup> Японы үндэсний үзэл. 2010. М.Энхсайхан (орч), Улаанбаатар. 135 дахь тал

Нишида Китаро “Их үйлсээс харагдахуйд” зохиолдоо философи болон шинжлэх ухаан өрнө дахинд илүү хөгжсөн хэмээн үзээд, “орчин үежих”, “баруунжих” гэсэн үзэл, хандлагыг японы үндэсний үзлийн ололтуудтай хослох хэрэгтэйг онцолжээ. Энэ талаар “Бидний сайн мэддэгээр, өрнөдийн сэхээтнүүд саяхнаас л оюун ухааны дүрслэлийн давуу байдал дахь өвөрмөц үзэл санаандаа анхаарлаа хандуулах болсон бөгөөд европ төвт оюун ухааны түүхийн төлөөллөө шүүмжилж эхэлсэн”<sup>25</sup> хэмээн тэрээр дүгнэжээ. Өөрөөр хэлбэл, хүний амьдралыг хувирган өөрчлөх гол зүйл бол дан ганц шинжлэх ухааны мэдлэг байж чадахгүй гэдгээ саяхнаас харж эхэлсэн ажээ. Энэ нь шинжлэх ухаан, техникийг эрчимтэй хөгжүүлэх нь нийгмийг сайн сайхан байдалд хүргэх ганц эх сурвалж мөн гэдэг хандлагадаа дүгнэлт хийж эхэлснийг тэрээр сайшаасан хэрэг юм.

Ийнхүү өрнийн соёл давамгайл болсон нөхцөл байдалд японы философи ямар ач холбогдолтой байх вэ?, ямар үүрэг гүйцэтгэх вэ? гэдгийг Нишида Китаро тодорхойлохыг зорьж байжээ. Түүний үндэсний үзэл нь япон бол дорнын үндэстэн тул өөрийн эзэмшлийн ертөнцийг өөрөөр хэлбэл, өрнөдөд танигдаагүй соёлын үнэт зүйлийг нээн илрүүлэхэд чиглэж байв. Нишида Китаро энэ тухай “Өрнийхөн өөрсдийн соёлоо бусдаас дээр гэж үздэг, бас хүн төрөлхтний соёл нь тэдний төрөлх хэлбэр лүү урагшилж байна гэж боддог, дорныхон ч гэсэн урагшилж хөгжиж байгаагаа өрнийн соёлд хүрч очих боломжтой боллоо гэж үздэг”<sup>26</sup> хэмээн нэгэнтээ шүүмжлэн бичсэн буй. Тэрээр өрнийн соёлын нөлөөг дэмжиж байсан хэдий ч дорнын соёлын ач холбогдлыг адилхан үнэлж хөгжих нь зүйтэй хэмээн үзжээ.

Ер нь бол гаднын соёл болон үндэсний уламжлалт соёлын харилцаа хамаарлыг зохистой түвшинд авч явах ухаан бидэнд хэрэгтэй. Аль нэг тал руу хэт туйлшрахгүй байх нь даяаршлын нөхцөлд үндэсний үзэл, уламжлал, соёлыг бэхжүүлж чадна. Үүний тулд аливаа үндэстэн ард түмэн хоорондоо өөрийн соёл уламжлалаа хуваалцан дэлгэрүүлэх хэрэгтэй юм. Энэ нь өөрсдийнхөө соёл уламжлалыг баяжуулах боломжийг бий болгодог ажээ.

Тэгвэл өнөөдөр даяаршил, мэдээлэл, технологийн эрчимтэй хөгжлийн эринд хүн төрөлхтөн соёл, иргэншлийн нийтлэг үнэт зүйлс, ашиг сонирхол болон үндэстний өвөрмөц байдлаа хадгалах ашиг сонирхлын зөрчлийг даван туулах зорилт улс үндэстнүүдийн өмнө тавигдаж, оновчтой шийдлийг хүлээж буй нэн чухал асуудал болж байна. Нишида Китарогийн үндэсний үзлээс тухайн газар нутгийн /жишээ нь өрнийн, дорнын/ үзэл ямагт өөрийн гэсэн өнгө аястай байсан, цаашид ч тийм байна гэсэн санааг олж харна. Тиймээс бид бусдын онцлог, эрх ашиг, бахархал, үнэт зүйл, үнэт сургаал номлолыг ухааран ойлгож хүндэтгэж сурах, улмаар зөв зохицож, хослуулах нь чухал гэсэн дүгнэлт хийж болох юм.

<sup>25</sup> Masao Abe. 1988. Nishida Kitaro Bibliography. Tokyo. 23 pp.

<sup>26</sup> Nishida Kitaro. 1973. *Art and Morality*, David Dilworth and Valdo Viglielmo (trans.), Honolulu. 29 pp

Өрнийн болон дорнын соёл ихээхэн ялгаатай гэдгийг Нишида Китаро хүлээн зөвшөөрсөн хэдий ч өрнийн болон японы үндэсний үзэл нь хоорондоо хослон шинэ үзэл санааг бий болгож болно гэж үзэж байлаа. Тэрээр дорно болон өрнө нь бие биенийхээ дутууг нөхөх ёстой бөгөөд хүн төрөлхтний ирээдүйн нийгэм зайлшгүй ийм нөхцөл байдлыг шаардана гэсэн санааг үндэсний үзлээрээ дэвшүүлж байсан нь оновчтой чухал санаа мөн.

Нишида Китаро философийн сургаалдаа даяарчлагдаж буй энэ ертөнцөд дорнын болон өрнийн соёлыг холбосон өвөрмөц онцлог соёл бий болох нь зайлшгүй зүйл хэмээн үзжээ. Учир нь бий болж байгаа соёл нь ирээдүйд хөгжлийн шинэ үзэл баримтлалыг бий болгоход хэрэгтэй гэдэгт тэрээр итгэлтэй байжээ. Тэрээр цааш нь, өнөөдрийн япон орон цаашдаа хаалттай, хоцрогдсон нийгэм биш болно, харин ч өөрийн соёл, үнэт зүйлээрээ бусдад үлгэр болно гэдгийг дээрх үзэл санаагаараа дамжуулан мөн илэрхийлсэн байдаг. Японы хөгжлийн зарчимд дэлхийн хөгжлийн зарчмыг тусгах хэрэгтэй юм. Энэ шинэ үзэл санаа нь эргээд бусад улс оронд ч нөлөөлөх болохыг ч тэрээр өгүүлжээ. Үнэхээр ч өнөөдөр Япон орон дэлхийн тэргүүлэх хөгжилтэй улс орон болон хөгжсөн нь Нишида Китарогийн философийн үзэл санаа биеллээ олжээ хэмээн хэлж болно.

Нишида Китаро "Сайн үйлийн тухай сургаал" хэмээх зохиолдоо XX зуунд японы философи нь өөрийн гэсэн өнгө төрхийг олох явдал чухал гэсэн санааг дэвшүүлээд зогсоогүй өөрөө үлгэрлэн бие даасан философийн систем боловсруулахыг зорьж байсан нь өнөөдөр түүний японы философийн түүхэнд оруулсан гол гавъяа байжээ. Монголчууд бид ч бас өөрсдийн оюуны эрхэм үнэт зүйл, язгуур эрх ашгийн асуудлаар өөрийн гэсэн философи үзэл баримтлалыг дэлхийн улс үндэснүүдийн өмнө тавьж, оновчтой шийдлийг хайх нь оюун санааны амьдралд нэн чухал ач холбогдолтой зүйл болох юм.

Тийнхүү Нишида Китаро нь зорилгоо хэрэгжүүлэх үүднээс өрнө болон дорнын үзлийн хослолд өөрийн философийн үзлээ хөгжүүлсэн билээ. "Өрнө" гэж чухам ямар арга барил байсан бэ? гэдгийг тодруулахын тулд тэрээр сүүлийн бүтээлдээ өрнийн философи, тэр дундаа Аристотелийн философи, шинэ кантч үзэл, германы философийг судлан, өөрийн философидоо шүүн тунгааж авч хэрэглэсэн. Эцэст нь тэрээр өрнөдөд бага танигдсан дорнын соёлын нөлөөг дээшлүүлэхийг зорьсон нь 1920-иод оны дундуур философид ноёлох байр суурьтай байсан Киотогийн их сургуулийн стандартад нийцэж эхэлсэн.

Тиймээс энэ сургуулийн сэтгэгчид марксист болон шинэ кантч үзэл болоод бусад нөлөө бүхий философи сургаалуудыг судлан, өөрийн философийг тэдэнтэй харьцуулах боломжтой эсэх дээр ажиллахаар нэгдэж эхэлсэн байна. Улмаар тэд Нишида Китарогийн дэвшүүлсэн үндэсний үзлийг дэмжиж, үйл ажиллагаандаа тусгаж ажиллахыг бусад судлаачиддаа уриалж байжээ. Өрнийн философийг японд нэвтрүүлэх талаар идэвхтэй ажиллаж байсан тухайн үеийн тэргүүний сэтгэгчид юуны өмнө өөрийн үндэсний үзлийн онцлог, давуу тал, үнэ цэнийг авч үзэн хойч үедээ ойлгуулах нь чухал юм байна

гэдэг дээр ийнхүү санал нэгдэж эхэлжээ.

Тухайн үед тус сургуулийн философийн үзэл баримтлал нь японы философийн нүүр царай нь болж байлаа. Ази тивд дорнын үзэл хэвээр хадгалагдаж байхад шинэчлэлийг амжилттай хийсэн үндэстэн болсон японд шинэчлэлийн он жилүүд үргэлжилсээр байсан юм. 1940-өөд оны эхээр шинэчлэлийн талаар хэд хэдэн цуврал симпозиум, дугуй ширээний хэлэлцүүлэг болсон байна. Тус цуврал хэлэлцүүлгээс гаргасан зөвлөмжид Нишида Китарогийн боловсруулсан философийн үзэл хийгээд үндэсний үзэл санааг бодит ажил хэрэг болгох тал дээр анхаарч ажиллахыг уриалсан байдаг. Энэ нь япон үндэстэн өсөн хөгжих, өөрсдийн соёлын үнэт зүйл, үндэсний үзлээ дээдэлж, хурц ширүүн өрсөлдөх чадварыг урамшуулсан хэрэг байжээ. Өөрөөр хэлбэл, XX зууны Японы оюуны хөгжил, дэвшлийн нэгэн гол хүч, хэрэгсэл болсон байна.

Энэ үеийн Нишидагийн философи үзлийн онцлог нь амьдралын философийн үзэл санаагаар баяжигдан тайлбарлагдаж байв. Ингэж хэлэх үндэслэл бол Дильтейгийн үзлийн философийн үзэл дэх “зовинол” хэмээх ойлголтыг өөрийн үзэлдээ тааруулан хэрэглэсэн. Энэхүү үндэсний шинж төрхийг мэдрэх зовинол нь хүмүүст үндэсний бахархалт үзлийг бий болгодог. Энэ нь үүрэг хариуцлагаа ухамсарласан эрхийг нийгэмд төлөвшүүлдэг гэж үзсэн нь үндэсний сайн сайхан байдал бол хувь хүний ирээдүйдээ санаа зовсон хандлагаас эхлэлтэй болохыг илэрхийлжээ.

Тэрээр “төрийг хүмүүсийн дотоод сэдлийн биелэл, ёс зүйн бодит байдал”<sup>27</sup> гэж үзэж байв. Энэ нь мөн тэдний үндэсний үзэл санааны илрэл болж өгчээ. Нишида Китарогийн үзлээр, үндэстэн өөрийгөө төрд хэрэгжүүлдэг. Түүхийн ертөнцөд орчнос бүрэлдүүлэгч субъект нь үндэстэн юм. Үндэстэн өөрийн ээлжинд субъектээ төлөвшүүлдэг. Үүнд л бүтээгдэж буйгаас бүтээгчид хэмээх зарчим оршино гэж үзжээ. Тэрээр нийтлэг (үндэстэн), нэгж (бодгал) хоёр “түүхийн бүтээлч үйл ажиллагааны” үзлийн үүднээс тэдгээр нь нэгдмэл байх ёстой гэж баталж байжээ.

Нишида Китаро өрнийн философийг судлах явцдаа үндэсний үзлээ илэрхийлж байсан. Хүнийг жинхэнэ утгаар нь танин мэдэх дорнын арга өрнийн мэдлэг ухаанаас давуутай гэж тэрээр үзэж байв. Тэрээр “Их үйлсээс харагдахуйд” зохиолынхоо оршилд хэлэхдээ: “Өрнийн соёлын хөгжлийн ололт амжилтаас хүндэтгэн дууриах, суралцахаар зүйл олон байх нь яриангүй. Гэвч хэдэн мянган жилийн туршид өөрийн гэсэн соёлын үнэт зүйл болж ирсэн дорнын соёлын хэлбэр эгшиггүй эгшиг сонсох юм мэт нуугдмал байдаг. Бидний сэтгэл байнга түүнд тэмүүлж байдаг. Бид энэ эрмэлзэлд философийн суурь тавьж өгөхийг хүсдэг юм”<sup>28</sup> хэмээжээ.

<sup>27</sup> Nishida Kitaro. 1990. *An Inquiry into the Good*, Masao Abe and Christopher Ives (trans.), Yale University Press, New Haven and London. 22 pp.

<sup>28</sup> 西田 幾多郎. 1927. 働く者から見る者へ.. 4 頁 /Hataraku mono kara miru mono e/

Өөрөөр хэлбэл, дорнын соёлын үндсийг дэлхий нийтэд таниулах буюу Нишида Китарогийн өөрийн хэлснээр “эгшиггүй мэт байгаа зүйлийн эгшгийг сонсох”-д түүний зорилго оршиж байжээ. Юуны өмнө тэрээр бүшидо ёсны сургаалын үнэ цэнийг япончууд өөрсдөө ухамсарлан ойлгох, улмаар дэлхий дахинд таниулахын чухлыг онцолж байсан байна. Түүний үндэсний үзлийн гол агуулга нь өөрийн үндэсний үзлээ уламжлан хөгжүүлж чадсан ард түмэн хөгжилд хүрдэг болохыг чухалчилсанд оршино.

#### SUMMARY

The main concept of his national pride in his philosophy of Nishida Kitaro is concern. In his view concern means responsibility. He said that individuals concern for one's county is a root for a county's development. He demanded Japanese intellectuals to compare themselves to the western intellectuals. This was his ambition to introduce western achievements into the Japanese society. It was a pattern of development. In his view this penetration can bring western competition into Japan. In his view it can intensity Japanese competitiveness.

#### НОМ ЗҮЙ

1. Masao Abe. Nishida Kitaro Bibliography. Tokyo, 1988
2. Nishida Kitaro. An inquiry into Good. Translated by Masao Abe and Christopher Ives. New Haven Yale University press, 1990
3. Nishida Kitaro. *Art and Morality*, David Dilworth and Valdo Viglielmo (trans.), Honolulu, 1973.
4. 西田 幾多郎. 働く者から見る者へ.. 4 頁 1927. /Hataraku mono kara miru mono e/
5. Д.Оюунгэрэл. “Нишида Китарогийн философийн үндсэн ойлголтууд”. МУИС. “Философи, шашин судлал” сэтгүүл. 2009 №318 (55)
6. Д.Оюунгэрэл. “Сайн үйл нь хүний амьдралын үндэс болох тухай Нишида Китарогийн үзэл”. Philosophy: Theory and Practice”. 2010.
7. Япон үндэсний үзэл. Орч., М.Энхсайхан. УБ.,2010